



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2023/11/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дундговь аймаг
2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

.....	0
1.Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	8
4. Аудитын тайлан.....	9
4.1 Ерөнхий зүйл.....	9
4.2 Материаллаг байдал.....	9
5. Аудитын илрүүлэлт	9
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	162

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын санал дүгнэлт



ДУНДГОВЬ АЙМГИЙН ГОВЬ-УГТААЛ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Т.АРИУНАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 157.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч, 2,738.5 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлж холбогдох хууль, журмын дагуу бүртгэл тайланд тусгасан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Засаг даргын Тамгын газар нь Аймгийн Засаг даргын 2022 оны Б/333 дугаар бүхий үндэслэлгүй захирамжаар төсвийн ерөнхийлөн захирагчид балансын урамшуулал олгосон зөрчил нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг буруу тайлагналын эрсдэл өндөр үнэлэгдсэн асуудал байлаа.

Бусад асуудлын хэсэг

0012020265

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 32 зорилт, 128 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 83.4 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	857,172.8	716,716.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	379,043.0	522,622.9
33	АВЛАГА	211,204.7	112,974.6
35	БАРАА МАТЕРИАЛ	266,925.1	81,119.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,483,783.1	1,260,385.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,483,783.1	1,260,385.6
39200	Биет хөрөнгө	3,399,168.4	1,238,102.1
39300	Биет бус хөрөнгө	84,614.7	22,283.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,340,955.9	1,977,102.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	49,529.0	20,300.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	49,529.0	20,300.0
41300	Өглөг	49,529.0	20,300.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,291,426.8	1,956,802.2
51	Засгийн газрын хувь оролцоо	4,291,426.8	1,956,802.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,459,192.7	465,524.7
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,459,192.7	465,524.7
51200	Хуримтлагдсан үр дүн	1,443,192.0	1,275,743.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,389,042.2	215,533.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,340,955.9	1,977,102.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,790,721.2	1,249,220.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	107,095.2	373,078.2
110	Орлогын албан татвар	26,207.9	170,243.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	26,207.9	170,243.7
113	Хөрөнгийн албан татвар	1,824.0	92,643.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	79,063.3	110,190.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	790,535.9	185,606.9
120	Нийтлэг татварын бус орлого	790,535.9	185,606.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,893,090.2	690,535.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,268,529.5	853,294.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,268,529.5	853,294.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,442,150.7	450,889.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,192,168.2	201,602.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	153,680.2	24,875.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191,157.4	25,097.1
2104	Хангамж, бараа материалын зардал	140,294.1	25,786.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,375.4	6,477.8
2107	Томилолт, зочны зардал	9,298.7	9,124.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,352.6	11,532.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	449,605.4	146,393.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	826,378.8	402,405.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	522,191.8	395,926.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	94,456.6	3,014,142.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	427,735.1	-2,618,216.8

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,388,496.1	3,388,496.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	475,195.6	475,195.6
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,863,691.7	3,863,691.7
4	Тайлант үеийн үр дүн	427,735.1	427,735.1
5	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,291,426.8	4,291,426.8
6	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,291,426.8	4,291,426.8
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	283,592.2	283,592.2
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,575,019.0	4,575,019.0
9	Тайлант үеийн үр дүн	-2,618,216.8	-2,618,216.8
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,956,802.2	1,956,802.2

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
П	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,258,955.7	850,945.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	786,131.5	639,094.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	737,157.3	591,050.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	295,908.0	239,834.7
210101	Үндсэн цалин	213,633.0	194,870.8
210102	Нэмэгдэл	69,902.9	31,995.9
210104	Урамшуулал	12,372.1	12,968.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,479.1	29,705.1
210201	Тэтгэврийн даатгал	26,972.3	21,040.6
210202	Тэтгэмжийн даатгал	3,126.7	2,475.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,501.5	1,926.6
210204	Ажилгүйдлийн даатгал	625.4	380.3
210205	Эрүүл мэндийн даатгал	6,253.2	3,882.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	207,276.9	203,443.9
210301	Гэрэл, цахилгаан	17,013.6	14,344.1
210302	Түлш, халаалт	188,763.3	188,719.8
210303	Цэвэр, бохир ус	1,500.0	380.0
2104	Хангамж, бараа материалын зардал	29,363.8	18,768.4
210401	Бичиг хэрэг	2,794.9	2,753.8
210402	Тээвэр, шатахуун	10,853.9	10,419.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,971.0	1,170.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,900.0	3,652.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	844.0	772.2
2105	Нормативт зардал	90.0	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	90.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,518.2	38,251.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,000.0	13,690.0
210604	Урсгал засвар	26,518.2	24,561.5
2107	Томилолт, зочны зардал	9,141.0	8,756.0
210702	Дотоод албан томилолт	9,141.0	8,756.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,619.5	8,942.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,500.0	7,500.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,387.8	151.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	320.5	290.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55.0	55.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,129.0	720.0
210807	Газрын төлбөр	227.2	226.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104,760.8	43,347.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	103,280.8	42,185.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,480.0	1,162.5

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,974.2	48,044.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,974.2	48,044.6
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,920.0	5,920.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,650.6	11,729.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,783.6	29,783.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	620.0	612.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	298,430.7	211,850.9
223001	Бусад хөрөнгө	298,430.7	211,850.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	174,393.5	0.0
230001	Эргэж төлөгдөх зээл	174,393.5	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,258,955.7	906,986.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	136,366.6	136,366.6
310001	Улсын төсвөөс санхүүжих	0.0	0.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	136,366.6	136,366.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	774,739.7	719,661.7
320001	Орон нутгийн төсвөөс	774,739.7	719,661.7
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	0.0	0.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	347,849.4	50,958.3
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,000.0	35,699.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,000.0	15,259.2
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	295,849.4	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	295,849.9
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	336,378.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,258,955.7	850,945.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	786,131.5	639,094.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	737,157.3	591,050.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	295,908.0	239,834.7
210101	Үндсэн цалин	213,633.0	194,870.8
210102	Нэмэгдэл	69,902.9	31,995.9
210104	Урамшуулал	12,372.1	12,968.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,479.1	29,705.1
210201	Тэтгэврийн даатгал	26,972.3	21,040.6
210202	Тэтгэмжийн даатгал	3,126.7	2,475.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,501.5	1,926.6
210204	Ажилгүйдлийн даатгал	625.4	380.3
210205	Эрүүл мэндийн даатгал	6,253.2	3,882.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	207,276.9	203,443.9
210301	Гэрэл, цахилгаан	17,013.6	14,344.1
210302	Түлш, халаалт	188,763.3	188,719.8
210303	Цэвэр, бохир ус	1,500.0	380.0
2104	Хангамж, бараа материалын зардал	29,363.8	18,768.4
210401	Бичиг хэрэг	2,794.9	2,753.8
210402	Тээвэр, шатахуун	10,853.9	10,419.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,971.0	1,170.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,900.0	3,652.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	844.0	772.2
2105	Нормативт зардал	90.0	0.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	90.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,518.2	38,251.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,000.0	13,690.0
210604	Урсгал засвар	26,518.2	24,561.5
2107	Томилолт, зочны зардал	9,141.0	8,756.0

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210702	Дотоод албан томилолт	9,141.0	8,756.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,619.5	8,942.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,500.0	7,500.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,387.8	151.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	320.5	290.8
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55.0	55.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,129.0	720.0
210807	Газрын төлбөр	227.2	226.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	104,760.8	43,347.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	103,280.8	42,185.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,480.0	1,162.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,974.2	48,044.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,974.2	48,044.6
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,920.0	5,920.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,650.6	11,729.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,783.6	29,783.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	620.0	612.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	298,430.7	211,850.9
223001	Бусад хөрөнгө	298,430.7	211,850.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	174,393.5	0.0
230001	Эргэж төлөгдөх зээл	174,393.5	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,258,955.7	906,986.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	136,366.6	136,366.6
310001	Улсын төсвөөс санхүүжих	0.0	0.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	136,366.6	136,366.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	774,739.7	719,661.7
320001	Орон нутгийн төсвөөс	774,739.7	719,661.7
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	0.0	0.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	347,849.4	50,958.3
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,000.0	35,699.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,000.0	15,259.2
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	295,849.4	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	295,849.9
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	336,378.9
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	17	17
610001	Төсвийн байгууллага	17	17
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	104	97
620001	Удирдах ажилтан	12	12
620002	Гүйцэтгэх ажилтан	55	51
620003	Үйлчлэх ажилтан	35	32
620004	Гэрээт ажилтан	2	2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,399.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	45,399.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,600.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	600.0
210104	Урамшуулал	600.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	666.8
210301	Гэрэл, цахилгаан	666.8
2104	Хангамж, бараа материалын зардал	10,462.2
210401	Бичиг хэрэг	775.0
210402	Тээвэр, шатахуун	1,489.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	195.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,002.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,621.3

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	2,960.0
210604	Урсгал засвар	661.3
2107	Томилолт, зочны зардал	368.0
210702	Дотоод албан томилолт	368.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,720.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,720.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,162.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,162.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,798.7
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	13,798.7
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	13,798.7
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	0.1
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	45,399.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,399.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,975.4
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,423.6
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(0.1)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.1

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг дарга нь төрийн үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг, Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тухайн байгууллага эрхэм зорилгоо “Иргэддээ тулгуурласан чадвартай хариуцлагатай нутгийн өөрөө удирдах байгууллагыг төлөвшүүлэн хөгжүүлэх, сумын тогтвортой хөгжлийг хангах үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд нь Засаг даргад бүх талын дэмжлэг үзүүлэх гаргасан шийдвэрийнх нь биелэлтийг хангуулах нутгийн захиргааны манлайллыг дээшлүүлж иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх гүйцэтгэл үр дүнд чиглэсэн удирдлагын тогтолцоо бүхий тасралтгүй суралцагч цомхон чадварлаг алба байхад оршино” гэж тодорхойлжээ.

3.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд Дундговь аймгийн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

3.2.1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,363,853.7 мянган төгрөгөөр буюу 54.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт №1.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн	857,172.8	716,716.6	(140,456.2)
Мөнгөн хөрөнгө	379,043.0	522,622.9	143,580.1
Авлага	211,204.7	112,974.6	(98,230.1)
Бараа материал	266,925.1	81,119.1	(185,806.0)
Үндсэн хөрөнгө	3,483,783.1	1,260,385.6	(2,223,397.5)

Нийт хөрөнгийн дүн	4,340,955.9	1,977,102.2	(2,363,853.7)
Нийт өр төлбөр	49,529.0	20,300.0	(29,229.0)
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,291,426.9	1,956,802.2	(2,334,624.7)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,340,955.9	1,977,102.2	(2,363,853.7)

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 143,580.1 мянган төгрөгөөр өссөн нь Байгаль хамгаалах сангийн ангийн орлого болон ОНЕО давж биелсэнтэй холбоотой.

Авлагын дансны үлдэгдэл 98,230.1 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн төвийн 108,530.5 мянган төгрөгийн ЭМД-ын сангаас авах цар тахлын дутуу санхүүжилт орж ирсэнтэй холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр 19,770.0 мянга, хандиваар 88,534.3 мянга, бусад эх үүсвэрээс 49,131.6 мянган төгрөгийн хөрөнгө орлогод авч бүртгэсэн байна. Харин 9,250.0 мянган төгрөгийн хөрөнгө акталж, бүтцийн өөрчлөлтөөр 2,738,528.7 мянган төгрөгийн хөрөнгийг улсын төсөвт шилжүүлсэн байна. Энэ нь Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,956,802.2 мянган төгрөг болж 2,334,624.7 мянган төгрөгөөр буурахад нөлөөлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” заасны дагуу Дундговь аймгийн Говь-Угтаал сумын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Д.Ихбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангаас нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 1,977,102.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 19,771.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 13,839.7 мянган төгрөгөөр тогтоосон.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитаар алдаа, зөрчилтэй асуудал илрээгүй.

5.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шүүд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нуггийн хөгжлийн	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	НИЙТ	6	1	5		1			

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 241,360.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 235,642.5 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 1,217.7 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 4,500.0 мянган төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага, 3 заалт бүхий зөвлөмж хүргүүллээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 2.4 хувийг залруулагдаагүй, 97.6 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил													
Засаг даргын Тамгын газар	1				1								
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1						1						
Дүн	2				1		1						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил													
Засаг даргын Тамгын газар	1	838.1	1	838.1		-							
Орон нутгийн хөгжлийн сан	1				1								
Дүн	2	838.1	1	838.1	1	-	-						
Нийт дүн	4	838.1	1	838.1	2	-	1	-	-	-	-	-	-